

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/014/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2026 оны 02 дугаар сарын 25

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор: Г.Энхзул
Утас: 99333147 Цахим хаяг: enkhzul@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН БУУЦАГААН
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Д.ЛХАГВАДОРЖ
ТАНАА

2026.02.25 № 2/121
танай _____-ны № _____-т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Байгууллагын Засаг даргын нөөц хөрөнгөөс 6,100.0 мянган төгрөгийг биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, баяр наадмын зардалд зарцуулсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгадагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	287,058,925.00	182,051,577.00
33	АВЛАГА	36,231,050.00	39,630,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	41,050.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	10,000.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	3,450,000.00
336	Зээлийн авлага	36,180,000.00	36,180,000.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	36,180,000.00	36,180,000.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	36,180,000.00	36,180,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	250,827,875.00	142,421,577.00
351	Түүхий эд материал	41,767,000.00	37,328,171.00
35110	Тусгай зориулалттай материал	41,767,000.00	37,328,171.00
354	Хангамжийн материал	168,483,493.00	92,116,396.00
35410	Бичиг хэргийн материал	4,514,138.00	1,749,194.00
35440	Түлш, шатах тослох материал	300,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	20,042,000.00	150,000.00
35470	Бусад хангамжийн материал	143,627,355.00	90,217,202.00
35600	Мал амьтад	40,577,382.00	12,977,010.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,136,999,363.91	3,167,682,329.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,136,999,363.91	3,167,682,329.87
392	Биет хөрөнгө	2,118,999,363.91	3,148,482,329.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,828,862,183.71	5,404,822,108.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,315,198,572.84)	(3,060,599,595.90)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	302,941,111.00	422,232,191.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(226,822,494.55)	(238,452,748.93)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	184,037,436.93	134,696,380.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(80,066,571.74)	(65,040,094.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	98,892,624.00	73,733,850.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(47,785,610.80)	(26,861,465.47)
39209	Зам, гүүрийн байгууламж	27,000,000.00	27,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(1,350,000.00)	(2,700,000.00)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	7,000,000.00	7,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	439,890,721.00	573,517,879.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(98,401,462.80)	(100,866,175.41)
393	Биет бус хөрөнгө	18,000,000.00	19,200,000.00
39301	Програм хангамж	13,978,000.00	00.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(13,978,000.00)	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	18,000,000.00	19,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,424,058,288.91	3,349,733,906.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,191,238.60	9,350,801.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,191,238.60	9,350,801.30
413	Өглөг	4,191,238.60	9,350,801.30
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,166,250.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,150,000.00	00.00
4136	Бусад өглөг	874,988.60	9,350,801.30
41361	Байгууллагад төлөх өглөг	874,988.60	9,350,801.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,419,867,050.31	3,340,383,105.57
51	Засгийн газрын хувь оролцоо	2,419,867,050.31	3,340,383,105.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	520,900,904.00	520,900,904.00
51101	Өмч: - төрийн	520,900,904.00	520,900,904.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,479,818,512.12	2,429,221,327.38

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	1,479,818,512.12	1,508,705,272.12
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	920,516,055.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	419,147,634.19	390,260,874.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,424,058,288.91	3,349,733,906.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,651,413,774.93	3,262,316,833.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	401,230,448.93	2,109,735,095.00
120	Нийтлэг татварын бус орлого	401,230,448.93	2,109,735,095.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,341,600.00	990,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	990,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,341,600.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,250,183,326.00	1,152,581,738.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,807,226.00	9,810,138.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,033,312.00	3,996,995.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,773,914.00	5,813,143.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,186,376,100.00	1,142,771,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,186,376,100.00	1,142,771,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,474,165,768.61	1,455,815,115.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,474,165,768.61	1,455,815,115.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,398,403,892.08	1,434,211,520.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	666,393,092.09	735,662,367.17
210101	Үндсэн цалин	405,794,431.48	447,398,138.69
210102	Нэмэгдэл	212,926,899.80	263,783,338.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,908,800.00	00.00
210104	Урамшуулал	18,417,000.00	18,870,490.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,345,960.81	5,610,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,828,284.08	86,065,279.50
210201	Тэтгэврийн даатгал	55,408,405.42	56,345,218.71
210202	Тэтгэмжийн даатгал	6,556,060.65	7,033,270.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,764,294.88	3,929,115.64
210204	Ажилгүйдлийн даатгал	3,219,265.39	3,516,635.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,880,257.74	15,241,040.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,179,318.00	77,155,953.42
210301	Гэрэл, цахилгаан	16,400,102.00	23,742,665.30
210302	Түлш, халаалт	45,779,216.00	52,447,956.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	965,332.12
2104	Хангамж, бараа материалын зардал	101,783,934.78	75,885,052.08
210401	Бичиг хэрэг	3,663,080.00	6,975,840.00
210402	Тээвэр, шатахуун	66,808,904.60	49,945,864.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,637,600.00	1,646,180.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	28,874,950.18	15,385,167.88
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	799,400.00	1,932,000.00
2105	Нормативт зардал	00.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,170,000.00	5,124,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	320,000.00	00.00

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	7,850,000.00	4,124,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,895,600.00	3,570,000.00
210702	Дотоод албан томилолт	8,895,600.00	3,570,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,115,551.75	64,892,124.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,725,699.75	58,574,532.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27,000.00	145,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,553,120.00	3,954,700.00
210807	Газрын төлбөр	650,232.00	1,402,792.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	299,500.00	315,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	372,038,111.38	384,856,744.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	78,628,200.00	67,884,580.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	600,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	293,409,911.38	316,372,164.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,761,876.53	21,603,594.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,912,880.00	15,574,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	15,169,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,629,708.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,683,172.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	405,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,848,996.53	6,029,594.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,848,948.59	6,029,594.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	177,248,006.32	1,806,501,717.90
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	21,591,666.50	885,985,662.64
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	21,591,666.50	885,985,662.64
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(21,591,666.50)	(885,985,662.64)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	155,656,339.82	920,516,055.26

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,251,524,926.00	1,150,131,738.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,341,600.00	990,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,341,600.00	990,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,341,600.00	990,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	990,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,341,600.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,250,183,326.00	1,149,141,738.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,807,226.00	9,820,138.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,033,312.00	3,996,995.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,773,914.00	5,823,143.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,186,376,100.00	1,139,321,600.00

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,186,376,100.00	1,139,321,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,197,270,826.00	1,120,161,738.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,197,270,826.00	1,120,161,738.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,121,537,049.47	1,098,388,143.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	661,293,600.00	719,557,646.70
210101	Үндсэн цалин	385,365,700.00	405,410,143.96
210102	Нэмэгдэл	237,586,000.00	258,402,800.00
210104	Урамшуулал	22,341,900.00	30,744,702.74
210105	Гэрээт ажлын хөлс	16,000,000.00	25,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,661,800.00	89,909,600.00
210201	Тэтгэврийн даатгал	56,210,000.00	61,138,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,612,900.00	7,192,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,306,500.00	3,596,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,306,500.00	3,596,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,225,900.00	14,385,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,179,318.00	71,400,599.97
210301	Гэрэл, цахилгаан	16,400,102.00	18,500,000.00
210302	Түлш, халаалт	45,779,216.00	49,900,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	2,999,999.97
2104	Хангамж, бараа материалын зардал	88,976,000.00	84,540,810.80
210401	Бичиг хэрэг	3,467,700.00	4,806,540.00
210402	Тээвэр, шатахуун	53,600,000.00	36,092,804.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,470,300.00	1,483,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	29,598,000.00	40,478,266.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	840,000.00	1,680,000.00
2105	Нормативт зардал	00.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,729,300.00	7,330,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,729,300.00	1,330,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,433,700.00	5,720,000.00
210702	Дотоод албан томилолт	6,433,700.00	5,720,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	126,047,327.47	63,242,132.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,647,595.47	57,104,240.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27,000.00	145,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,563,000.00	3,544,000.00
210807	Газрын төлбөр	650,232.00	1,402,792.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	299,500.00	425,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,216,004.00	55,687,354.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,216,004.00	55,087,354.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,733,776.53	21,773,594.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,884,780.00	15,744,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	15,144,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,629,708.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,655,072.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	600,000.00

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,848,996.53	6,029,594.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,848,948.59	6,029,594.53
213404	Хөрөнгийн	47.94	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	54,254,100.00	29,970,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	54,254,100.00	29,970,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,254,100.00	29,970,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	54,254,100.00	29,970,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	54,254,100.00	29,970,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(54,254,100.00)	(29,970,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,900,904.00	419,147,634.19	1,320,112,172.30	2,260,160,710.49
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	520,900,904.00	419,147,634.19	1,320,112,172.30	2,260,160,710.49
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	155,656,339.82	155,656,339.82
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,900,904.00	419,147,634.19	1,479,818,512.12	2,419,867,050.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	28,886,760.00	28,886,760.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	520,900,904.00	419,147,634.19	1,508,705,272.12	2,448,753,810.31
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	(28,886,760.00)	00.00	(28,886,760.00)
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	920,516,055.26	920,516,055.26
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,900,904.00	390,260,874.19	2,429,221,327.38	3,340,383,105.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,174,557,000.00	1,137,879,639.47	36,677,360.53	96.88
Татварын бус орлого	1,174,557,000.00	1,137,879,639.47	36,677,360.53	96.88
Нийтлэг татварын бус орлого	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	223,216,800.00	0.00	223,216,800.00	0.00
Тусламжийн орлого	950,340,200.00	1,136,879,639.47	(186,539,439.47)	119.63
Төсвөөс санхүүжих	950,340,200.00	1,136,879,639.47	(186,539,439.47)	119.63
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,174,557,000.00	1,137,879,639.47	36,677,360.53	96.88
УРСГАЛ ЗАРДАЛ	1,174,557,000.00	1,137,879,639.47	36,677,360.53	96.88
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,136,049,000.00	1,122,135,639.47	13,913,360.53	98.78
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	719,276,800.00	719,242,796.70	34,003.30	100.00
Үндсэн цалин	405,303,400.00	405,095,293.96	208,106.04	99.95

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Нэмэгдэл	258,402,800.00	258,402,800.00	0.00	100.00
Урамшуулал	30,570,600.00	30,744,702.74	(174,102.74)	100.57
Гэрээт ажлын хөлс	25,000,000.00	25,000,000.00	0.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,909,600.00	89,909,600.00	0.00	100.00
Тэтгэврийн даатгал	61,138,600.00	61,138,600.00	0.00	100.00
Тэтгэмжийн даатгал	7,192,800.00	7,192,800.00	0.00	100.00
ҮОМШӨ-ний даатгал	3,596,300.00	3,596,300.00	0.00	100.00
Ажилгүйдлийн даатгал	3,596,300.00	3,596,300.00	0.00	100.00
Эрүүл мэндийн даатгал	14,385,600.00	14,385,600.00	0.00	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,400,600.00	71,400,599.97	0.03	100.00
Гэрэл, цахилгаан	18,500,000.00	18,500,000.00	0.00	100.00
Түлш, халаалт	49,900,600.00	49,900,600.00	0.00	100.00
Цэвэр, бохир ус	3,000,000.00	2,999,999.97	0.03	100.00
Хангамж, бараа материалын зардал	88,680,000.00	85,482,660.80	3,197,339.20	96.39
Бичиг хэрэг	6,000,000.00	4,806,540.00	1,193,460.00	80.11
Тээвэр, шатахуун	37,320,000.00	36,092,804.80	1,227,195.20	96.71
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,350,000.00	2,110,200.00	239,800.00	89.80
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	41,010,000.00	40,793,116.00	216,884.00	99.47
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,680,000.00	320,000.00	84.00
Нормативт зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	16,000,000.00	16,000,000.00	0.00	100.00
Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
Томилолт, зочны зардал	11,200,000.00	5,720,000.00	5,480,000.00	51.07
Дотоод албан томилолт	11,200,000.00	5,720,000.00	5,480,000.00	51.07
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,582,000.00	81,134,232.00	4,447,768.00	94.80
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	77,445,000.00	75,623,340.00	1,821,660.00	97.65
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	0.00	800,000.00	0.00
Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00	0.00	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	527,000.00	145,100.00	381,900.00	27.53
Тээврийн хэрэгслийн оношлогоо	310,000.00	121,000.00	189,000.00	39.03
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,500,000.00	2,917,000.00	583,000.00	83.34
Газрын төлбөр	2,000,000.00	1,402,792.00	597,208.00	70.14
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	425,000.00	75,000.00	85.00
Бараа үйлчилгээний бусад зардал	53,000,000.00	52,245,750.00	754,250.00	98.58
Бараа үйлчилгээний бусад зардал	53,000,000.00	52,245,750.00	754,250.00	98.58
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,508,000.00	15,744,000.00	22,764,000.00	40.89
Бусад урсгал шилжүүлэг	38,508,000.00	15,744,000.00	22,764,000.00	40.89
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	29,160,000.00	15,144,000.00	14,016,000.00	51.93
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,348,000.00	600,000.00	8,748,000.00	6.42
АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25	0.00	100.00
Удирдах ажилтан	9	9	0.00	100.00
Гүйцэтгэх ажилтан	14	14	0.00	100.00
Үйлчлэх ажилтан	2	2	0.00	100.00

2.6 Нэмэлт санхүүжилт тайлан

Дансны нэр, төрөл	Тайлант он
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,977,504.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,977,504.00
Тусламжийн орлого	5,977,504.00
Хандив тусламж /дотоод/	5,977,504.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	5,977,504.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,661,800.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,315,704.00
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,977,504.00
УРСГАЛ ЗАРДАЛ	5,977,504.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,977,504.00
Хангамж, бараа материалын зардал	1,080,900.00
Тээвэр, шатахуун	900,900.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	4,496,604.00
Бараа үйлчилгээний бусад зардал	3,896,604.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь “Төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, ардчилал шударга ёсыг тогтоох, хууль дээдлэх төрийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх, ажил үйлчилгээг хөнгөн шуурхай жигд хүртээмжтэй явуулах, төсөв санхүүгийн хэмжээг тодорхойлох, эцсийн үр дүнг үнэлж дүгнэх, нийгмийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэхэд гол зорилго оршино” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэллээ.

Тайлант онд Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 3,349,733.9 мянган төгрөг болж өмнөх оноос 925,675.6 мянган төгрөг өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	287,058.9	182,051.6	(105,007.3)
Авлага	36,231.1	39,630.0	3,399.0
Бараа материал	250,827.9	142,421.6	(108,406.3)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,136,999.4	3,167,682.3	1,030,683.0
Үндсэн хөрөнгө	5,920,602.1	6,662,202.4	741,600.3
Хуримтлагдсан элэгдэл	(3,783,602.7)	(3,494,520.1)	289,082.6
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,424,058.3	3,349,733.9	925,675.6
Өр төлбөр	4,191.2	9,350.8	5,159.6
Засгийн газрын хувь оролцоо	2,419,867.1	3,340,383.1	920,516.1
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,424,058.3	3,349,733.9	925,675.6

Авлага дансны үлдэгдэл 39,630.0 мөнгөн төгрөг болж өмнөх оноос 3,399.0 мянган төгрөгөөр өссөн байна. Нэмэлт санхүүжилтийн дансны зардлын эрх нээгдээгүйгээс 3,450.0 мянга төгрөгийн татаас, санхүүжилтийн авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 142,421.6 мянган төгрөг болж өмнөх оноос 108,406.3 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд бараа материал төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 117,713.8 мянган төгрөгөөр, шилжүүлэн авсан 37,769.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 131,794.4 мянган төгрөгийн хугацаа дууссан, ашиглах боломжгүй хөрөнгүүдийг акталж устгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,662,202. мянган төгрөг болж өмнөх оноос 741,600.3 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 29,970.0 мянган төгрөгөөр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 7/41 дугаар “Хөрөнгөд

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

эзэмшигч тогтоох тухай” тогтоолоор 106,900.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны 8/52 дугаар “Хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай” тогтоолоор 116,226.4 мянган төгрөгийн хөрөнгө, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны 81 дугаар “Хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай” тогтоолоор тус тус үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн ИТХ-ын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 7/42 дугаар “Хөрөнгө акталж данснаас хасах тухай” тогтоолоор 49,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 77,491.2 мянган төгрөгийн хөрөнгө, аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 9/60 дугаар “Хөрөнгө акталж данснаас хасах тухай” тогтоолоор 457,454.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 9,350.8 мянган төгрөг болж өмнөх оноос 5,159.6 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд санхүүжилт дутуу орж ирсэнтэй холбоотой гэрэл цахилгааны 5,242.7 мянга, шуудан холбооны 594.0 мянга, түлш халаалтын 2,547.4 мянга, байгууллагад төлөх 966.8 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Тус байгууллага нь Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ны Acolous accounting system 4.0 санхүүгийн программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашигладаг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,408,898.2 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,435,893.1 мянган төгрөгөөр бууруулж, урьд оны үлдэгдлээс 223,216.8 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, 1,196,221.9 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотголоор 1,174,557.0 мянган төгрөгөөр тодотгожээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 1,174,557.0 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсоноос урсгал үйл ажиллагаанд 1,137,879.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	756,095.5	744,401.7	11,693.8	98.5
2	80106 Баг, хорооны ҮАЗардал	224,806.5	214,390.1	10,416.4	95.4

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	29,160.0	15,144.0	14,016.0	51.9
4	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	50,000.0	49,995.8	4.3	100.0
5	81701 Байгаль орчныг хамгаалах, нөхө	74,445.0	73,955.0	490.0	99.3
6	82212 Хур хог хаягдал, орчны бохирдл	40,050.0	39,993.1	56.9	99.9
	Нийт дүн	1,174,557.0	1,137,879.6	36,677.4	96.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тайлант онд байгууллагын дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.13.4 дахь заалтыг үндэслэн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/109 дугаар “Хоолны мөнгө олгох тухай” тушаалаар Багийн Засаг дарга, Орлогч дарга, Тамгын газрын дарга нарт 05 дугаар сарын хоолны мөнгийг ажлын 1 өдрийн 10.0 мянга, 06 дугаар сарын хоолны мөнгийг ажлын 1 өдрийн 20.0 мянган төгрөгөөр тооцож нийт 15,396.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг олгосон байна.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар 24 албан тушаалтны орон тоог баталж, төсвийн тодотголоор биеийн тамирын арга зүйч, операторын орон тоог бууруулж, гүйцэтгэлээр 22 орон тоотой 809,186.4 мянган төгрөгийн цалингийн сантай ажиллаж байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нийт 9,810.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, 6,222.5 мянган төгрөгийг зарцуулж, 3,587.6 мянган төгрөгийг орон нутгийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна. Тайлант онд хагас жилийн мал тооллогын зардалд 1,972.5 мянга, жилийн эцсийн хүн ам, орон сууцны тооллогын зардалд 1,080.9, тендерийн бичиг баримт бичиг хэргийн зардалд 245.0 мянга, байгаль хамгаалах санд 624.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 45,400.0 мянган төгрөгийн ЗДТГ-ын шатахуун нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар монгон шалгаруулахаар төлөвлөж, “НИК” ХХК-тай 42,577.0 мянган төгрөгийн газрын тосны бүтээгдэхүүн зээлээр нийлүүлэх гэрээг байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 2/154 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Сонгосон суурь үзүүлэлт болох 2025 оны анхны батлагдсан төсөв 1,196,221.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 11,962.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 163 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан бөгөөд 3 мэдээллийг хугацаа хоцроосон шалтгаан нь 2025 оны төсөв хугацаандаа ирээгүй тул худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хоцроож, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,075,622.8 мянган төгрөгийн 39 гүйлгээ,

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 122,939.7 мянган төгрөгийн 16 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 217,676.8 мянган төгрөгийн 25 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно аудит хийгээгүй.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, аудитаар 106,199.0 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 169,574.4 мянган төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоосон ба тус байгууллагаас 2026 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 1а/129 дугаартай албан бичгээр аудитын шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлснийг хянаж үнэлсэн.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	106,199.0	4	106,199.0	100%
Төлбөрийн акт	6	169,574.4	6	169,574.4	100%
Нийт дүн	10	275,773.4	10	275,773.4	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,677.4 мянган төгрөгийн 4 зөрчил¹ илэрсэнд 1 төлбөрийн акт, цаашид давтан гаргахгүй байх зөрчлийг арилгах 3 албан шаардлага өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 6,677.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс Баяр наадмын бөхийн барилдааны бай шагналд 2,300.0 мянга, Малчид төлчдийн зөвлөгөөнийг тохиолдуулан Хангайн бүсийн сумдын үндэсний бөхийн барилдааны шагналд 3,000.0 мянга, нийт 5,300.0 мянган төгрөгийг бөхийн шагналд олгож зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.8 дахь "Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

тэмцээн зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулдаг байдлыг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

5.1.2 Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 11 газар байхад нягтлан бодох бүртгэлд 5 газар бүртгэлтэй ба газрын гэрчилгээ болон нягтлан бодох бүртгэлд тусгасан талбайн хэмжээ 45,338 м.кв-аар бага зөрүүтэй мэдээлэл зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", 13 дугаар зүйл, 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газрын хэмжээг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай тулган баталгаажуулж нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаж, зөрчил арилгах албан шаардлага өгөв.

5.1.3 Тайлант онд байгууллагын ёс зүйн дэд хорооны даргад үнсэн цалингийн 45 хувьтай тэнцэх хэмжээний 577.4 мянган төгрөгийн нэмэгдэл урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж, уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь "Төсвийн байгууллага, түүний албан тушаалтан", 3.2 дахь "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

5.2 Төлбөрийн акт

5.2.1 Хангайн бүсийн сумдын ИТХ, ЗДТГ-ын албан хаагчдын туршлага судлах, урлаг спортын арга хэмжээнд нэмэлт санхүүжилтийн данснаас спортын арга хэмжээний бооцооны 800.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.8 дахь "Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 800.0 мянган төгрөгийг төсөв захирагч, нягтлан бодогч нараар 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс Баяр наадмын бөхийн барилдааны бай шагналд 2,300.0 мянга, Малчид төлчдийн зөвлөгөөнийг тохиолдуулан Хангайн бүсийн сумдын үндэсний бөхийн барилдааны шагналд 3,000.0 мянга, нийт 5,300.0 мянган төгрөгийг бөхийн шагналд олгож зориулалт бусаар зарцуулсан байна.	1	5,300.0			1	5,300.0							
Хангайн бүсийн сумдын ИТХ, ЗДТГ-ын албан хаагчдын туршлага судлах, урлаг спортын арга хэмжээнд нэмэлт санхүүжилтийн данснаас спортын арга хэмжээний бооцооны 800.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	800.0	1	800.0									
Тайлант онд байгууллагын ёс зүйн дэд хорооны даргад үнсэн цалингийн 45 хувьтай тэнцэх хэмжээний 577.4 мянган төгрөгийн нэмэгдэл урамшуулал олгосон байна.	1	577.4			1	577.4							
Нийт дүн	3	6,677.4	1	800.0	2	5,877.4							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 11 газар байхад нягтлан бодох бүртгэлд 5 газар бүртгэлтэй ба газрын гэрчилгээ болон нягтлан бодох бүртгэлд тусгасан талбайн хэмжээ 45,338 м.кв-аар бага зөрүүтэй мэдээлэл зөрүүтэй байна.	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		

-----oOo-----





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 114/А0571284/БНА-2026/014/НА-
СА-ТШЗ Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бууцагаан сумын ЗДТГ-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 11 газар байхад нягтлан бодох бүртгэлд 5 газар бүртгэлтэй ба газрын гэрчилгээ болон нягтлан бодох бүртгэлд тусгасан талбайн хэмжээ 45,338 м.кв-аар бага, мэдээлэл зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", 13 дугаар зүйл, 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газрын хэмжээг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай тулган баталгаажуулж нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаж, зөрчил арилгаж, нотлох баримтыг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

8428030367

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Бууцагаан сумын ЗДТГ-ын дарга Д.Лхагвадорж, нягтлан бодогч А.Отгонцэцэг нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АУДИТОР:



Г.ЭНХЗУЛ

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

² Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 115/АОСН1284/БНА-2026/014/НА-СА
Номгон
ЛМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бууцагаан сумын ЗДТГ-ын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс Баяр наадмын бөхийн барилдааны бай шагналд 2,300,000 (Хоёр сая гурван зуун мянган) төгрөг, Малчид төлчдийн зөвлөгөөнийг тохиолдуулан Хангайн бүсийн сумдын үндэсний бөхийн барилдааны шагналд 3,000,000 (Гурван сая) төгрөг, нийт 5,300,000 (Таван сая гурван зуун мянган) төгрөгийг бөхийн шагналд олгож зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.8 дахь "Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн хөрөнгөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулдаг байдлыг таслан зогсоож, зөрчлийг арилгасан талаарх нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.


8426030363

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Бууцагаан сумын ЗДТГ-ийн дарга Д.Лхагвадорж, нягтлан бодогч А.Отгонцэцэг нар даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР:



Г.ЭНХЗУЛ

1

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторовн 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 117/АОСГ 1284/БНА-2026/014/НА-
СТА-ТМЗ Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бууцагаан сумын ЗДТГ-ын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд байгууллагын ёс зүйн дэд хорооны даргад цалингийн 45 хувьтай тэнцэх хэмжээний 577,350 (Таван зуун далан долоон мянга гурван зуун тавин) төгрөгийн нэмэгдэл урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж, уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь "Төсвийн байгууллага, түүний албан тушаалтан", 3.2 дахь "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө" гэсэн заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал 2026 онд олгохгүй байх зөрчлийг

6426030369

арилгасан талаарх нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Бууцагаан сумын ЗДТГ-ийн дарга Д.Лхагвадорж, нягтлан бодогч А.Отгонцэцэг нарт даалгав^{1 2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Г.ЭНХЗУЛ

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

² Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 41/АДСГ 12 84/БНА-2026/014/НА-
АН-ТМЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бууцагаан сумын ЗДТГ-ын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хангайн бүсийн сумдын ИТХ, ЗДТГ-ын албан хаагчдын туршлага судлах, урлаг спортын арга хэмжээнд нэмэлт санхүүжилтийн данснаас спортын арга хэмжээний бооцооны 800,000 (Найман зуун мянган) төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.8 дахь "Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:


1. Зориулалт бусаар зарцуулсан 800,000 (Найман зуун мянган) төгрөгийг төсөв захирагч, нягтлан бодогч нараар нөхөн төлүүлж Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлж, зөрчлийг арилгасан талаарх нотлох баримтыг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Бууцагаан сумын ЗДТГ-ын дарга Д.Лхагвадорж, нягтлан бодогч А.Отгонцэцэг нарт даалгав^{1, 2}.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР:



¹Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

²Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно